



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 261


Улаанбаатар хот

Дархлаажуулалтын тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Дархлаажуулалтын тухай хуулийн 10.6 дах заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Нөхөн дархлаажуулалт хийх журмыг нэгдүгээр, Дархлаажуулалтын өмнө эмчийн үзлэг хийх журмыг хоёрдугаар, Дархлаажуулалтын кабинетын ажиллах журмыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү журмыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү), Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2001 оны 34 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын 1 дэх заалт, 2012 оны 217 дугаар тушаалын 7 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/-т даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080884

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 07 сарын 07 өдрийн
261 дугаар тушаал 1 дүгээр
хавсралт

НӨХӨН ДАРХЛААЖУУЛАЛТ ХИЙХ ЖУРАМ

Нийтлэг үндэслэл:

Монгол Улсын Дархлаажуулалтын тухай хуулийн 3.1.3, 10.6 заалтуудыг хэрэгжүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

Нөхөн дархлаажуулалтад заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолын дагуу эхлэл болон дархлал сэргээх тунгаас хоцорсон хүүхдийг байнга хамруулна. Нөхөн дархлаажуулалтыг магадлан итгэмжлэл бүхий эрүүл мэндийн байгууллага харьяалал харгалзахгүйгээр хийнэ.

Дархлаажуулалт хийхийн өмнө их эмчийн үзлэг хийж, ямар төрлийн вакциныг нөхөн хийлгэх тухай тэмдэглэлийг эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэнэ. Нөхөн дархлаажуулсан тухай мэдээг хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээний "нөхөн" дархлаажуулалтыг тэмдэглэх гэсэн хэсэгт тэмдэглэх ба тайланг батлагдсан маягтын дагуу сар бүр Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын албанд ирүүлнэ.

Нэг. Халдварт саагийн эсрэг вакцины нөхөн дархлаажуулалт:

1.1. Халдварт саагийн эсрэг вакцинд хамрагдаагүй 2 хүртэлх насны хүүхдэд товлолын дагуу вакциныг сарын зайтай 3 удаа нөхөж хийнэ.

1.2. Халдварт саагийн эсрэг вакцины бүрэн тунд хамрагдаагүй хүүхдэд тун хоорондын алдагдсан хугацааг харгалзалгүйгээр дараагийн тунг үргэлжлүүлэн хийнэ.

1.3. Урьд нь халдварт саагийн эсрэг вакцинд хамрагдсан эсэх нь тодорхойгүй, бичиг баримтгүй хүүхдийг нас харгалзахгүйгээр сарын зайтай 2 удаа дархлаажуулна.

Хоёр. Тавт (Сахуу, хөхүүл ханиад, татран В гепатит, хемофилюс имфлюенза В) вакцины нөхөн дархлаажуулалт:

2.1. Тавт вакциныг урьд нь огт тариулаагүй 1 хүртэлх насны хүүхдэд нэг сарын зайтай 3 удаа тарина.

2.2. Тавт вакцины бүрэн тунд хамрагдаагүй 1 хүртэлх насны хүүхдийг тун хоорондын алдагдсан хугацааг харгалзалгүйгээр дараагийн тунг үргэлжлүүлэн тарина.

Гурав. Улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг вакцины нөхөн дархлаажуулалт:

3.1. Улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг вакцинд хамрагдаагүй 4 хүртэлх насны хүүхдийг нэг сарын зайтай 2 удаа дархлаажуулна.

3.2. Хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд элсэн ороход нь улаанбурхан, гахай хавдар, улаануудын вакцинд хамрагдсан эсэхийг сургуулийн эмч шалгаж, товлолын дагуу вакцинд хамрагдаагүй 6 настай хүүхдийг 2 удаа нэг сарын зайтай дархлаажуулна.


3.3. Улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг вакциныг огт тариулаагүй, тариулсан эсэх нь тодорхойгүй 7-15 насны хүүхдийг нэг удаа дархлаажуулна.

Дөрөв. Сүрьеэгийн эсрэг вакцины нөхөн дархлаажуулалт:

4.1. Сүрьеэгийн эсрэг вакциныг амаржих газар тариулаагүй 2 сар хүртэлх насны хүүхдэд сүрьеэтэй өвчтөнтэй тархвар судлалын холбогдолгүй бол туберкулины сорил тавихгүйгээр дархлаажуулна.

4.2. Хоёр сартайгаас 1 хүртэлх насны хүүхдэд туберкулины сорил тавьж, сөрөг гарсан тохиолдолд дархлаажуулна.

4.3. Сүрьеэгийн вакциныг товллын дагуу тариулсан боловч 1, 3, 12 дах сартайд нь ажиглалт хийн вакцины дараах сорви /хэлбэр хэмжээг шалгах/ үүсээгүй бол туберкулины сорил тавьж сөрөг тохиолдолд дахин 1 удаа дархлаажуулна.



Тав. В вирус хепатитийн эсрэг вакцины нөхөн дархлаажуулалт:

5.1. В вирус хепатитийн эсрэг вакцины төрөх тунд /24 цагийн дотор/ хамрагдаагүй хүүхдийг нэг сарын дотор нөхөн дархлаажуулж, тавт вакциныг түүнээс 1 сарын дараагаас товллын дагуу үргэлжлүүлэн тарина.

Зургаа. А вирус хепатитын эсрэг вакцины нөхөн дархлаажуулалт:

6.1. А вирус хепатитийн эсрэг вакцинд огт хамрагдаагүй 3 хүртэлх насны хүүхдийг 1 удаа дархлаажуулна.

Долоо. Сахуу, татрангийн эсрэг вакцины нөхөн дархлаажуулалт:

7.1. Сахуу, татрангийн эсрэг вакцинд хамрагдаагүй 7-15 насны хүүхдийг 1 удаа дархлаажуулна.

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 07 сарын 07 өдрийн
26.1 дугаар тушаал 2 дугаар
хавсралт

ДАРХЛААЖУУЛАЛТЫН ӨМНӨ ЭМЧИЙН ҮЗЛЭГ ХИЙХ ЖУРАМ

Монгол Улсын Дархлаажуулалтын тухай хуулийн 13.4 заалтыг хэрэгжүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

Нэг. Дархлаажуулалтын өмнө хүүхдэд эмчийн үзлэг хийх нь хүүхдийн биеийн байдлыг үнэлж, вакцин хийхэд харшлах өвчин, эмгэг байгаа эсэхийг тогтоож, дархлаажуулалтын дараах хүндрэлээс сэргийлэх зорилготой.

1.1. Дархлаажуулалт хийхийн өмнөх үзлэгийг амаржих газарт нярайн эмч, 2 сартайгаас дээш насны хүүхдэд сум, өрхийн эмч, хүүхдийн эмч хийнэ. Шаардлагатай тохиолдолд эмч нарын зөвлөгөөнөөр хэлэлцэн сэргийлэх тарилгад хамрагдах эсэх, ямар вакцинд хамруулах асуудлыг товлон бичгээр өгнө.

1.2. Эмчийн үзлэгээр вакцин хийлгэхэд харшлах өвчин эмгэггүй хүүхдийг вакцинд хамруулах бөгөөд ямар төрлийн вакцинд хамрагдах, хэд дэх тун, вакцинд хамрагдах өдөр, хугацааг амаржих газарт нярайн түүх, сум өрх, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт “Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-т тэмдэглэнэ.

1.3. Дархлаажуулалт хийхийн өмнө эмч үзлэг хийхдээ өмнөх дархлаажуулалтын дараа урвал илэрсэн эсэх, ямар урвал илэрсэн, төрөлтийн явц, өмнө нь өвдсөн өвчин эмгэг, хийлгэсэн эмчилгээ, гэр бүлийн гишүүдийн удамшлын байдал, ямар нэгэн зүйлийн харшилтай эсэхийг эцэг, эхээс сайтар асууж тэмдэглэнэ.

1.4. Сум, өрх, багийн эмч нар дархлаажуулалтад хамрагдсан 2 хүртэлх сартай хүүхдэд нярайн эргэлтийн хугацаанд хүүхдийн биеийн байдалд ажиглалт хийж, БЦЖ вакцины сорвижилтыг хянаж, сорвижилтын байдлыг тэмдэглэнэ.

1.5. Долоо болон арвантаван настай хүүхдэд товллын дагуу сахуу, татрангийн эсрэг вакциныг ерөнхий боловсролын сургуулийн эмч, багш, эрүүл мэндийн ажилтнаар дамжуулан эцэг, эх, асран хамгаалагч нарт вакцин хийх тухай мэдээллийг бичгээр мэдэгдэж, тарилга хийхийн өмнө хүүхэд бүрт эмчийн үзлэг хийж, харшлах өвчин, эмгэггүй хүүхдийг дархлаажуулан сэргийлэх тарилгын гэрчилгээнд тэмдэглэнэ.

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 07 сарын 07 өдрийн
26/ дугаар тушаал 3 дугаа
хавсралт

ДАРХЛААЖУУЛАЛТЫН КАБИНЕТИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Магадлан итгэмжлэл бүхий эрүүл мэндийн байгууллага эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэм баримтлан, хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн аюулгүй шаардлага хангасан нөхцөлд дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулна.

Нэг. Ерөнхий шаардлага:

1.1. Аймаг, дүүргийн эрүүл мэндийн төв, салбар амбулатори, бүсийн оношлогоо эмчилгээний төвийн дархлаажуулалтын кабинетийг 2-3 өрөөтэй байхаар зохион байгуулна. Дархлаажуулалтын кабинет нь вакцин, биобэлдмэл, дагалдах хэрэгслийг хадгалах агуулах, сувилагчийн буюу вакцин тарих өрөө, хүлээлгийн өрөөтэй байна.

1.2. Дархлаажуулалтын кабинетийг өвчтөний үзлэгийн өрөө, тасаг, палатаас тусдаа байхаар зохион байгуулна.

1.3. Өрх, сумын эрүүл мэндийн төв, сум дундын эрүүл мэндийн төв, төрөх тасаг, амаржих газрын дархлаажуулалтын кабинетийг 1-2 өрөөтэй байхаар зохион байгуулна. Сувилагчийн буюу вакцин тарих өрөө, хүлээлгийн өрөөтэй байна.

1.4. Дархлаажуулалттай холбоотой хууль, тогтоол, тушаал, арга зүйн зөвлөмжийн эмхэтгэл, гарын авлага, вакцин тарих заавар, сургалт, сурталчилгааны материал, сэргийлэх тарилгын карт, вакцин биобэлдмэлийн орлого, зарлагын дэвтэр, хэм, хяналтын дэвтэр, дархлаажуулалтын тайлангийн маягтууд байна.

Хоёр. Эрүүл ахуйн нөхцөл, халдвараас сэргийлэх дэглэм:

2.1. Дархлаажуулалтын кабинетийн өрөө нь зохиомол гэрэлтүүлэг өдрийн 150 люкс, ердийнх 75 люкс, байгалийн хангалттай гэрэлтүүлэгтэй, өрөөний хэм 20-22 C⁰, салхивчтай, хана тааз нь тосон будгаар будагдсан, шалыг плита, паркет хулдаасын аль нэгээр бүрсэн байна.

2.2. Кабинет нь гар угаах халуун, хүйтэн ус бүхий угаалтуур, нянгийн эсрэг үйлчилгээтэй шингэн саван, гар арчих нэг удаагийн хэрэглээний алчуур, спиртийн агууламж 70-80%-тай гар халдваргүйжүүлэх бодисоор хангагдсан байх бөгөөд мэдрэгчтэй гар угаагууртай байна.

2.3. Төвлөрсөн усан хангамжгүй газарт гоожуурт угаагуурыг ашиглаж болно. Гоожуур болон ус нөөцлөх савыг өдөр бүр цэвэрлэж, халдваргүйтгэнэ.

Гурав. Дархлаажуулалтын кабинетэд байх тоног, төхөөрөмж, багаж хэрэгслэл:

3.1. Вакцин хадгалах зориулалтын хөргөгч, вакцин зөөвөрлөх сав, хэм заагуур, хөлдөлтийг тандагч заагуур, мөсөн элемент зэрэг вакцины хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийг байрлуулсан байна.

3.2. Эмч, сувилагч, эх, хүүхдэд зориулсан ширээ, сандлууд, тэргэнцэр бүхий ширээ, сэргийлэх тарилгын карт хадгалах шүүгээ, өлгий вандан, аюулгүй хайрцаг, хөлөөр онгойдог хогийн сав, углааш зэргийг байрлуулна.

3.3. Адреналин, анальгин, атрофин, кордиамин, дексаметазон, преднизолон, седуксин, супрастин, эуфиллин, эфедрин зэрэг яаралтай тусламжийн эм, бэлдмэлтэй хайрцаг байна.

Дөрөв. Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын гүйцэтгэх үүрэг:

4.1. Дархлаажуулалтын кабинетийн эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг сайтар мөрдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах.

4.2. Дархлаажуулалтад шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгах.

4.3. Дархлаажуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн, кабинетийн сувилагчийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах.

4.4. Дархлаажуулалтын үйл ажиллагаанд дотоодын хяналтыг тогтмол хийх.

4.5. Вакцинатор сувилагчийг мэргэжлийн сургалт, давтан сургалтад хамруулах.

4.6. Вакцинатор сувилагчийг орлон ажиллах сувилагч бэлтгэх.

Тав. Дархлаажуулалтын асуудал хариуцсан мэргэжилтний гүйцэтгэх үүрэг:

5.1. Дархлаажуулалтын үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангах.

5.2. Дархлаажуулалтад хамрагдвал зохих 0-15 насны хүүхдийн бүртгэл, судалгааг сум, өрхийн эмчээр гаргуулж, сар, жилийн тарилгын төлөвлөгөө хийж, хоцорсон хүүхдийг нөхөн дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулах

5.3. Дархлаажуулалтын нэгжийн үйл ажиллагаа, кабинетийн эрүүл ахуйн нөхцөл, халдвараас сэргийлэх дэглэм, бичиг баримтын хөтлөлт, хүйтэн хэлхээ, вакцины хадгалалт, тээвэрлэлт, дархлаажуулалтын хамралтад төлөвлөгөөт дэмжлэгт, хяналт хийж эргэн мэдээлэх, зөвлөмжийг бичгээр өгөх, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих.

5.4. Дархлаажуулалтын хамралт, зарцуулалтын сар, улирал, хагас, бүтэн жилийн тайлан, мэдээг батлагдсан маягтын дагуу бүрэн гүйцэд гаргах.

5.5. Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл /ДДУХ/-ийн тандалтыг зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн багийг ажиллуулж, холбогдох мэдээллийг мэргэжлийн болон хяналтын байгууллагад хүргүүлэх.

5.6. Дархлаажуулалт бүхий халдварт өвчин, ДДУХ бүртгэгдсэн тохиолдолд тархвар зүйн судалгаа, тандалт хийж эх уурхай, дамжсан зам, шалтгааныг тогтоох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах.

5.7. Дархлаажуулалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, санал, дүгнэлт боловсруулан байгууллагын захиргаа болон холбогдох байгууллагад танилцуулж шийдвэрлүүлэх.

5.8. Дархлаажуулалтын талаарх сургалтыг эмч, сувилагч нарт тасралтгүй зохион байгуулах.

5.9. Дархлаажуулалтад шаардлагатай вакцин, биобэлдмэл, дагалдах хэрэгслэл хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн хангалт зэрэг вакцин менежментийн үйл ажиллагааг зохион байгуулах.

Зургаа. Дархлаажуулалтын кабинетийн сувилагчийн үүрэг:

6.1. Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолын дагуу дархлаажуулах, нөхөн, нэмэлт, тархвар судлалын заалтаар хийгдэх дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах.

6.2. Дархлаажуулалтын кабинетын эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан ажиллах.

6.3. Вакциныг баталгаат унаагаар тээвэрлэн авч, орлого, зарлагын тооцоог өдөр тутам хийж, холбогдох мэдээ тайланг тогтоосон хугацаанд нь дээд шатны байгууллагад хүргүүлэх.

6.4. Тарилгын стандартыг баримтлан, аюулгүй тарилгын техникийг мөрдөн ажиллах.

6.5. Хөргөгч, хөлдөөгчний хэм, хяналтын бүртгэлийг холбогдох журмын дагуу хийж, тэмдэглэл хөтлөх.

6.6. Хөргөгч, хөлдөөгчийг дугаарлаж, вакциныг төрөл, сери, дуусах хугацааг тэмдэглэн шошгожуулах.

6.7. Хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжинд доголдол гарсан тохиолдолд байгууллагын захиргаанд яаралтай мэдэгдэж шийдвэрлүүлэх.

6.8. Хүүхдийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчид хийх гэж буй вакцины нэр, хэд дэх тун, дуусах хугацааг танилцуулан, дархлаажуулалт хийсний дараа 30 минут эмчийн хяналтад байлгах. ДДУХ-ийн тохиолдол бүртгэгдсэн үед яаралтай мэдээлэх, шаардлагатай мэдээ, мэдээллийг судалгааны багт гаргаж өгөх

